ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2021/89/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он


Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033

Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805

Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955

Цахим хаяг:Gantuya.o@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ **Error! Bookmark not defined.**
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ **Error! Bookmark not defined.**
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ **Error! Bookmark not defined.**
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ **Error! Bookmark not defined.**
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан **Error! Bookmark not defined.**
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ **Error! Bookmark not defined.**
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ **Error! Bookmark not defined.**
3. Аудитын тайлан ........ 15
3.1. Ерөнхий зүйл ........ 15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ........ 15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ........ 15
3.4. Материаллаг байдал ........ 16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ........ 16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ........ 17
3.7. Шилэн дансны мэдээлэл ........ 18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18
3.9. Аудитын илрүүлэлт ........ 19
Залруулсан алдаа ........
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ........ 19
Аудитын зөвлөмж ........
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ........ **Error! Bookmark not defined.**
4. Менежментийн захидал ........ **Error! Bookmark not defined.**
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ........ **Error! Bookmark not defined.**

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2021. 02. 25 № 25
танай_____________-ны № _______________-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА
С.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, заабрын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

**СТ-1А**

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **310,233,685.74** | **320,114,712.45** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 310,233,685.74 | 320,114,712.45 |
| **351** | **Түүхий эд материал** | 171,549,009.75 | 186,981,219.75 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 171,137,486.75 | 185,609,219.75 |
| 35130 | Эм боох материал | 411,523.00 | 1,372,000.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 00.00 | 00.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 3,225,360.00 | 3,975,360.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 105,686,901.99 | 103,354,020.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 25,788,768.99 | 16,868,552.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,690,500.00 | 6,970,231.50 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 85,000.00 | 2,215,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 873,100.00 | 3,910,854.20 |
| 35450 | Барилгын засварын материал | 3,433,250.00 | 2,707,100.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 22,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 70,816,283.00 | 70,660,283.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 00.00 | 00.00 |
| 35600 | Мал амьтад | 29,772,414.00 | 25,804,112.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,888,989,453.27** | **3,488,773,694.89** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 00.00 | 00.00 |
| 37330 | Урт хугацаат хөрөнгө оруулалт-зам, гүүр | 00.00 | 00.00 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,888,989,453.27 | 3,488,773,694.89 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,263,924,453.27 | 2,863,921,194.85 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,844,138,573.00 | 1,850,268,795.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -105,108,024.04 | -141,844,126.24 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 587,791,444.04 | 760,207,111.30 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -487,690,206.56 | -519,579,185.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,633,403,747.96 | 1,670,390,232.27 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -335,894,339.24 | -873,494,522.41 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 85,488,493.89 | 87,592,528.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -38,137,630.70 | -53,725,094.92 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 00.00 | 00.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 69,223,600.00 | 69,223,600.00 |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 00.00 | 00.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,094,745.00 | 18,834,745.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,385,950.08 | -3,952,889.28 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 00.00 | 00.00 |
| 39217 | Ном | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **393** | **Биет бус хөрөнгө** | 625,065,000.00 | 624,852,500.04 |
| 39301 | Програм хангамж | 425,000.00 | 425,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -212,499.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 624,640,000.00 | 624,640,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,199,223,139.01** | **3,808,888,407.34** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,199,223,139.01** | **3,808,888,407.34** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,199,223,139.01 | 3,808,888,407.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,056,964,936.51 | 2,056,964,936.51 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,056,964,936.51 | 2,056,964,936.51 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,068,340,272.28 | 678,005,540.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,068,340,272.28 | 1,068,340,272.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -390,334,731.67 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | 00.00 | 00.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,073,917,930.22 | 1,073,917,930.22 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | 00.00 | 00.00 |
| 51600 | Нөөцийн сан | 00.00 | 00.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,199,223,139.01** | **3,808,888,407.34** |

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **7,326,782,062.55** | **7,818,272,524.05** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **00.00** | **00.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,864,423,340.55** | **3,760,525,087.05** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,864,423,340.55 | 3,760,309,087.05 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,864,423,340.55 | 3,467,262,057.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,008,698,259.00 | 3,458,682,875.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 00.00 | 00.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 00.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 855,725,081.55 | 8,579,182.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 00.00 | 216,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 00.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 00.00 | 216,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,462,358,722.00** | **4,057,747,437.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,717,480,100.00 | 2,802,469,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,717,480,100.00 | 2,802,469,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 744,878,622.00 | 1,255,277,537.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 00.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 00.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,228,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 225,906,706.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 518,971,916.00 | 1,250,049,537.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 00.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 00.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,858,273,321.21** | **8,208,607,255.72** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,858,273,321.21** | **8,208,607,255.72** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,777,494,891.21 | 8,071,961,880.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,776,170,357.00 | 6,857,480,016.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,517,789,221.00 | 2,276,627,364.89 |
| 210102 | Нэмэгдэл | 1,185,599,319.00 | 2,679,228,015.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 241,224,418.00 | 483,702,171.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,831,557,399.00 | 1,417,922,465.11 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 124,641,380.00 | 156,510,071.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,323,130.00 | 10,760,644.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 43,300.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 34,600.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,700.00 | 00.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 113,231,650.00 | 145,749,427.29 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,344,610.00 | 63,712,627.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,739,521.00 | 21,522,549.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,221,446.00 | 28,260,226.19 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,383,643.00 | 13,929,852.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 179,446,779.42 | 218,799,270.99 |
| 210401 | Бичиг хэрэг | 42,389,324.51 | 30,276,408.99 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 122,892,717.91 | 153,319,555.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,612,869.00 | 13,469,463.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 710,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,265,472.00 | 12,503,060.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 00.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,286,396.00 | 8,520,784.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,932,427.00 | 47,690,673.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,480,097.00 | 4,850,673.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,452,330.00 | 42,840,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 64,974,553.00 | 24,871,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 3,125,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 64,974,553.00 | 21,746,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,682,850.00 | 7,458,800.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,682,850.00 | 7,458,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 89,309,518.00 | 44,758,889.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 79,845,687.00 | 40,687,251.50 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 944,663.00 | 859,972.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 320,000.00 | 620,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,765,300.00 | 2,400,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 233,868.00 | 191,665.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 440,992,416.79 | 650,679,833.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,790,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,120,000.00 | 2,080,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 417,082,416.79 | 648,599,833.23 |

| | | | |
|---|---|---|---|
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 80,778,430.00 | 136,645,374.91 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,662,446.00 | 55,827,150.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,662,446.00 | 55,827,150.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 67,115,984.00 | 80,818,224.91 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | 00.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 66,583,184.00 | 56,362,336.20 |
| 213304 | Хөрөнгийн | 532,800.00 | 24,455,888.71 |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | 00.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **468,508,741.34** | **-390,334,731.67** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **468,508,741.34** | **-390,334,731.67** |

**СТ-2А**

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **6,471,056,981.00** | **7,516,620,330.00** |
| 118304 | Нохойны албан татвар | 00.00 | 00.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,008,698,259.00** | **3,458,812,647.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,008,698,259.00 | 3,458,812,647.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 00.00 | 00.00 |
| 120002 | Хүүгийн орлого | 00.00 | 00.00 |
| 120003 | Торгуулийн орлого | 00.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 3,008,698,259.00 | 3,458,812,647.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,008,698,259.00 | 3,458,812,647.00 |
| 141001 | Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр | 00.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,462,358,722.00** | **4,057,807,683.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,717,480,100.00 | 2,802,469,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,717,480,100.00 | 2,802,469,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 744,878,622.00 | 1,255,337,783.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 5,228,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,340,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 742,538,622.00 | 1,250,109,783.00 |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | 00.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **6,413,557,731.00** | **7,509,945,330.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,413,557,731.00** | **7,509,945,330.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,335,091,747.00** | **7,373,439,070.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,776,170,357.00 | 6,857,809,147.11 |
| 210101 | Үндсэн цалин | 1,902,127,164.00 | 2,276,893,711.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,165,139,600.00 | 2,679,290,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 240,352,793.00 | 483,702,171.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,468,550,800.00 | 1,417,922,465.11 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 124,641,380.00 | 156,510,073.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,323,130.00 | 11,654,927.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 43,300.00 | 00.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 34,600.00 | 00.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,700.00 | 00.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 113,231,650.00 | 144,855,146.29 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 61,344,610.00 | 65,212,627.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,739,521.00 | 21,522,549.00 |
| 210302 | Түлш, халаалт | 30,221,446.00 | 29,760,226.19 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,383,643.00 | 13,929,852.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 00.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 146,991,600.00 | 169,338,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 19,797,522.00 | 20,773,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 118,280,359.00 | 130,946,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,612,869.00 | 13,484,950.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 710,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,300,850.00 | 3,424,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,946,900.00 | 44,814,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,214,870.00 | 1,202,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,409,230.00 | 42,862,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,322,800.00 | 750,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 94,031,357.00 | 32,323,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 94,031,357.00 | 28,323,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,682,850.00 | 7,458,800.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,682,850.00 | 7,458,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 81,662,393.00 | 37,891,972.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 73,632,430.00 | 34,012,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 944,663.00 | 859,972.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 320,000.00 | 620,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,765,300.00 | 2,400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,620,300.00 | 2,080,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,620,300.00 | 2,080,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **78,465,984.00** | **136,506,259.91** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 11,350,000.00 | 55,688,035.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,350,000.00 | 55,688,035.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 67,115,984.00 | 80,818,224.91 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 00.00 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | 00.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 66,583,184.00 | 56,362,336.20 |
| 213304 | Хөрөнгийн | 532,800.00 | 24,455,888.71 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **57,499,250.00** | **6,675,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **57,499,250.00** | **6,675,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **57,499,250.00** | **6,675,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 57,499,250.00 | 6,675,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 57,499,250.00 | 6,675,000.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 00.00 | 00.00 |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | 00.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-57,499,250.00** | **-6,675,000.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| 250005 | Төлсөн ногдол ашиг | 00.00 | 00.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

**СТ-4А**

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,056,964,936.51 | 1,073,917,930.22 | 447,609,415.94 | 00.00 | 3,578,492,282.67 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,056,964,936.51** | **1,073,917,930.22** | **447,609,415.94** | **00.00** | 3,578,492,282.67 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 468,508,741.34 | 00.00 | 468,508,741.34 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,056,964,936.51** | **1,073,917,930.22** | **1,068,340,272.28** | **00.00** | 4,199,223,139.01 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,056,964,936.51** | **1,073,917,930.22** | **1,068,340,272.28** | **00.00** | 4,199,223,139.01 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,056,964,936.51** | **1,073,917,930.22** | **1,068,340,272.28** | **00.00** | 4,199,223,139.01 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -390,334,731.67 | 00.00 | -390,334,731.67 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,056,964,936.51** | **1,073,917,930.22** | **678,005,540.61** | **00.00** | 3,808,888,407.34 |

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 6,228,780,600.00 | 6,204,920,210.80 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 6,228,780,600.00 | 6,204,920,210.80 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,220,580,600.00 | 6,198,660,210.80 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,803,058,200.00 | 5,782,825,201.11 |
| 210101 | Үндсэн цалин | 2,145,115,500.00 | 2,126,960,102.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,681,368,400.00 | 2,679,290,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 00.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 976,574,300.00 | 976,574,299.11 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 117,919,500.00 | 117,542,460.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 117,919,500.00 | 117,542,460.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,213,800.00 | 65,212,627.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 21,522,600.00 | 21,522,549.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29,760,900.00 | 29,760,226.19 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,930,300.00 | 13,929,852.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 137,904,600.00 | 137,904,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,923,000.00 | 13,923,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 108,590,600.00 | 108,590,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,257,000.00 | 11,256,950.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 710,000.00 | 710,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,424,000.00 | 3,424,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37,725,000.00 | 37,725,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,123,000.00 | 1,123,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 35,852,000.00 | 35,852,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 750,000.00 | 750,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35,320,000.00 | 35,319,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 31,320,000.00 | 31,319,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,459,500.00 | 7,458,800.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,459,500.00 | 7,458,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,880,000.00 | 12,591,972.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,000,000.00 | 8,712,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 860,000.00 | 859,972.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 620,000.00 | 620,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,400,000.00 | 2,400,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2100000.00 | 2080000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,100,000.00 | 2,080,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8200000.00 | 6260000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,200,000.00 | 6,260,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,700,000.00 | 6,260,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,228,780,600.00 | 6,204,920,210.80 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,802,469,900.00 | 2,746,107,563.80 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,802,469,900.00 | 2,746,107,563.80 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 3,426,310,700.00 | 3,458,812,647.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,426,310,700.00 | 3,458,812,647.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 1,020.00 | 58,301.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 555.00 | 7,878.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 455.00 | 4,545.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 45,878.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **00.00** | **00.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 00.00 | 00.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 00.00 | 00.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 00.00 | 00.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга С.Цэрэнсамбуу танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд эд хариуцагчийн зартыг анхан шатны батлагдсан маягтаар хөтлөх, эд хариуцагч солигдоход тооллого хийж баталгаажуулж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв. Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 39/02-619 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Хэв журам, аюулгүй байдлыг ханган, хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс 2020 оны 09 сард Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны эхний 09 сарын баримтанд санхүү аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж дараах зөрчлүүдийг илрүүлсэн байна. Үүнд:

1. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас ирүүлсэн тооцооны баримтыг үндэслэн нэг албан хаагчид дунджаар 2.5-10.0 сая төгрөгийн нэмэгдэл цалин урамшуулал олгогдсон бөгөөд энэ нь гэрээт албан хаагч цэргийн байнгын тэтгэвэрт гарах тохиолдолд тэтгэвэр болон 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж нь хэвийн хэмжээнээс илүү тогтоогдож, төсвийн зардал хэтрэх эрсдлийг үүсгэсэн байна.
2. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас цагдаагийн газрын дансанд сар бүрийн 20-ны өдрөөс хойш санхүүжилт хийгдэж байгаагаас гэрээт албан хаагчдын урьдчилгаа цалинг төсвийн зардлаас олгож байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.3.2 дэх заалтыг зөрчсөн.

3. Дотоодын цэргийн 816-р тусгай салбарын захирагч нь төсөв зарцуулах эрхгүй бөгөөд албан хаагчдын цалин нэмэх хасах тушаал , нэмэгдэл урамшуулал олгох тоцоог баталж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4.1.38, 16.1, 16.5 дахь заалтуудыг зөрчсөн.

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 6,143,479.2 мянган төгрөгөөс *1* хувиар буюу 61,434.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлого 7,818,272.5 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул *1* хувиар буюу 78,182.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 390,334.7 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 310,233.7 | 320,114.7 | 9,881.0 |
| Үндсэн хөрөнгө | 3,888,989.4 | 3,488,773.7 | -400,215.7 |
| **Нийт хөрөнгө** | 4,199,223.1 | 3,808,888.4 | -390,334.7 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,199,223.1 | 3,808,888.4 | -390,334.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 4,199,223.1 | 3,808,888.4 | -390,334.7 |

Мөнгөн хөрөнгө, авлага болон урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 320,114.7 мянган төгрөг болж 9,881.0 мянган төгрөгөөр өссөн нь бэлэн бүтээгдэхүүн, тусгай зориулалтын материалын дансны үлдэгдлээс шалтгаалжээ. Энэ нь цагдаагийн ерөнхий газраас дотоод шилжүүлгээр ирсэн тусгай зориулалтын цахилгаан бороохой, энгэрийн камер, гав, тоон гарын үсгийн тээгч, дата сим, хийн буу, сум зэрэг 21,707.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалуудыг бараа материал дансанд орлого авч үлдэгдлээр үлдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал бүртгэгдээгүй байна. Акталсан бараа материал байхгүй, 8,520.7 мянган төгрөгийн малын зүй бус хорогдол мал амьтад данснаас хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,488,773.7 мянган төгрөг болж тайлант оны 648,559.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна. Үндсэн хөрөнгийн дансанд өөрийн хөрөнгөөр 3,850.0 мянган төгрөгийн цахим хурлын төхөөрөмж, аймгийн хөрөнгө оруулалтаар 2,825.0 мянган төгрөгөөр дижитал камер авсан, дээд газрын дотоод шилжүүлгээр болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 70,833.3 мянган төгрөгийн авто машин 28,821.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, авто тээврийн үндэсний төвөөс 6,130.2 мянган төгрөг гэрлийн шон болон 9,112.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, орон нутгийн төсвөөс 125,590.0 мянган төгрөгийн 7 тээврийн хэрэгсэл, 2,850.0 мянган төгрөгийн замын хяналтын камер, 1,221.0 мянган төгрөгийн хөлдөөгч, принтер зэргийг орлогод авсан байна. Тээврийн хэрэгсэл данснаас 24,007.6 мянган төгрөгийн авто машин акталсан байна.

2020 оны санхүүгийн тайланд биет бус хөрөнгө, өр төлбөр дансанд урт болон богино хугацаат өр төлбөр бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,808,888.4 мянган төгрөг болж тайлант оны үр дүн 390,334.7 мянган төгрөгөөр буурсан байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 491,490.4 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,350,333.9 мянган төгрөгөөр буюу 19.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин 1,081,309.7 мянган төгрөг, НДШ 31,868.7 мянган төгрөг, тогтмол зардал 2,368.0 мянган төгрөгөөр тус тус зардлууд өссөн байна. Энэ нь МУ-ын засгийн газрын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 сараас цалин нэмэгдсэн, мөн ахлагч бүрэлдэхүүнийг ТТ-7-ТТ8 шатлалд шилжүүлсэн, төрийн тусгай алба хаасны нэмэгдлийг Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор нэмэгдсэн байна. Тогмол зардлын нэмэгдэл нь 2020 онд цахилгаан болон усны үнэ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга нь бүртгэгдээгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжих 2,983,441.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3,298,917.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 6,282,358.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 180,971.1 мянган төгрөгөөр бууруулж 2,802,469.9 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 127,393.1 мянган төгрөгөөр өсгөж 3,426,310.7 мянган төгрөгөөр нийт 6,228,780.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,228,780.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,802,469.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоор 3,426,310.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,746,107.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3,458,812.6 мянган төгрөг, нийт 6,204,920.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 6,148,557.9 мянган төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 32501.9 мянган төгрөг, 23,860.4 мянган төгрөгийн зардлын хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын хэмнэлт 23,860.4 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 20,232.9 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 377.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 1.2 мянган төгрөгөөр,томилолтын зардал 0.7 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 0.4, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 1,288.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 20.0 бусад урсгал шилжүүлэг зардлыг 1,940.0 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд гэрээт байгууллага болох Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 968,136.0 мянган төгрөг, Монгол банкнаас 19,208.5 мянган төгрөг, АЗДТГ-аас олон нийтийн байцаагчийн урамшуулал 176,407.4 мянган төгрөг, бусад төсөл хөтөлбөрөөс 52,879.2 мянган төгрөг, АИТХ-аас төсөл хөтөлбөрийн 14,328.5 мянган төгрөг, Эрдэнэт сангаас 24,378.0 мянган төгрөг нийт 1,255,337.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс гэрээт байгууллагуудын цалин урамшууллын зардалд 1,074,983.9 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 38,967.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 31,434.0 мянган төгрөг, нормативт зардалд 7,089.8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 3678.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 25,300.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 49,428.0 мянган төгрөг нийт 1,230,881.9 мянган төгрөгийг зарцуулж, 24,455.8 мянган төгрөгийг цалингийн зардлын хэмнэлтийг төвлөрүүлсэн байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 1 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш 7,264,937.4 мянган төгрөгийн 55 орлогын, 453,844.0 мянган төгрөгийн 22 зарлагын, 192,045.0 мянган төгрөгийн худалдан авалтын 48 гүйлгээг мэдээллэсэн байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 1 | | 1 | | | | |
| Нийт дүн | 1 | | 1 | | | | |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,013.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9,415.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 598.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Орлого үр дүнгийн тайланд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардлаас 894.2 мянган төгрөгийг тэтгэврийн даатгалын шимтгэлд гүйлгэж бүртгэсэн, бараа материалын тодруулга тайланд малын нас дэвшилт болон зүй бусын хорогдлын 8520.7 мянган төгрөгийг нэг бүртгэснийг зарлага бүрээр тус тусад нь бүртгэж залруулав.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 598.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 598.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Газрын даргын 2020 оны 11 сарын 16-ны Б/227 дугаар тушаалаар гэрээт цагдаагийн хэлтсийн нягтлан бодогч А.Ариунтуяад няравын ажлыг хавсруулан 149.3 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д ”Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Баривчлах байранд нийт 935 иргэн хүлээн авснаас 10 иргэний 449.0 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д “хуулийн дагуу улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Хууль зүй дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2018 оны А63/70 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.2-т ”баривчлах байрны орлогыг төсвийн байгууллагын төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэн зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Үндсэн үйл ажиллагааны орлогыг үндсэн дансанд төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нягтлан бодох бүртгэл, бодлогын үйл ажиллагаа

*1.1.* *Илрүүлэлт:*

Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны өдрийн 347 дугаар "Маягт заавар батлах тухай" тушаалаар батлагдсан албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл НХ Маягт БМ-10 маягтаар хөтлөөгүй байна.

*1.2.* *Эрсдэл:*
Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

*Өгсөн зөвлөмж:*

Албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны өдрийн 347 дугаар "Маягт заавар батлах тухай" тушаалаар батлагдсан НХ Маягт БМ-10 маягтаар хөтлөж байх.

Нягтлан бодох бүртгэл, бодлогын үйл ажиллагаа

*2.1* *Илрүүлэлт:*

2020 оны 10 сарын 01-нд эд хариуцагч нярав Х.Үүрийнтуяа ажлаас чөлөөлөгдөхөд тооцооны нягтлан бодогч А.Ариунтуяад ажлыг хавсруулан гүйцэтгүүлэхээр өгсөн ч эд хөрөнгийн тооллогыг хийж баримтжуулж баталгаажуулаагүй байна.

*2.2* *Эрсдэл:*
Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

*Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ. 12.2.2-т эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэсэн заалтыг хэрэгжүүлж хөрөнгийн тооллого, тооцоог хийж баримтжуулж байх.*Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Орхон аймаг дахь Цагдаагийн газарт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.02.25-ны 39/02-1437 тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ЭРДЭНЭ Огноо:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР О.ГАНТУЯА

Орхон аймаг дахь Цагдаагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо: 2021 | Аудитын нэр: | *Орхон аймаг дахь Цагдаагийн газар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит* | Аудитын код: САГ-2021/89/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Орхон аймаг дахь Цагдаагийн газар** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сангийн сайдын 2017 оны 12 сарын 05-ны өдрийн 347 дугаар "Маягт заавар батлах тухай" тушаалаар батлагдсан албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл НХ Маягт БМ-10 маягтаар хөтлөөгүй байна. | | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | С.Цэрэнсамбуу Г.Дамчаа |
| 2 | 2020 оны 10 сарын 01-нд эд хариуцагч нярав Х.Үүрийнтуяа ажлаас чөлөөлөгдөхөд тооцооны нягтлан бодогч А.Ариунтуяад ажлыг хавсруулан гүйцэтгүүлэхээр өгсөн ч эд хөрөнгийн тооллогыг хийж баримтжуулж баталгаажуулаагүй байна. | | Зөвлөмж | Дарга, нягтлан бодогч | С.Цэрэнсамбуу Г.Дамчаа |
| 3 | Газрын даргын 2020 оны 11 сарын 16-ны Б/227 дугаар тушаалаар гэрээт цагдаагийн хэлтсийн нягтлан бодогч А.Ариунтуяад няравын ажлыг хавсруулан 149.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 149.3 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | С.Цэрэнсамбуу Г.Дамчаа |
| 4 | Баривчлах байранд нийт 935 иргэн хүлээн авснаас 10 иргэний 449.0 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй байна. | 449.0 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | С.Цэрэнсамбуу Г.Дамчаа |
| | **ДҮН** | **149.3** | | | |

АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТЫГ

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ЭРДЭНЭ Огноо:

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР О.ГАНТУЯА

(ОРА-2021/89/СТА-ТШЗ) 11